



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/04

Улаан эрэг

Баянмөнх сумын Соёлын төвийн бүтэц,
орон тоог батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.7 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 83 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Сумын Соёлын төвийн үйлгэрчилсэн дүрэм"-ийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт "Соёл, урлаг, биеийн тамир, спортын салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт", Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалтны жагсаалт"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Баянмөнх сумын Соёлын төвийн бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан бүтэц орон тооны дагуу албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан баталж, гэрээ байгуулан үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллахыг Соёлын төвийн дарга (Ц.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА *Ц.Болдбаатар* О.НЯМДАВАА



Сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр
сарын 15 ны өдрийн 1104 дугаар захирамжийн
хавсралт



Соёлын төвийн бүтэц, орон тоо

№	Орон тоо	Мэргэжилтний тоо
1	Соёлын төвийн дарга	1
2	Номын санч	1
3	Хөгжмийн багш	1
4	Орон нутаг судлах танхимын ажилтан	1
5	Нярав, сантехникч	1
6	Үйлчлэгч	1
7	Нягтлан бодогч	0.5
Нийт		6.5